

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ” гэж заасан байдаг.

Ашигт малтмал, газрын тосны газрын ирүүлсэн статистик мэдээллээр 2014-2017 оны хооронд 1483 хайгуулын тусгай зөвшөөрөл олгож байсан. Харин 2018-2021 оны хооронд 144 тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар олгосон нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үзүүлэлт 90.3 хувиар буурсан. Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ буурсантай холбоотойгоор сүүлийн жилүүдэд хайгуулын ажлын хэмжээ, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт эрс буурч, ашигт малтмалын орд шинээр илрүүлэн улсын эрдэнэсийн санг арвижуулж Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангах талаар батлагдсан төрийн бодлого алдагдахад хүрч байна.

Уг асуудлыг шийдвэрлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/67 дугаар тушаалаар “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг баталж, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг түргэн шуурхай, ил тод, нээлттэй цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах...” гэж заасан байдаг.

Иймд байгаль орчин тэр дундаа усан сан бүхий газар, газрын доорх усны нөөцтэй давхцалтай хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдохоос сэргийлж Усны тухай хуулийн 17 зүйлийн 17.2-д “Тухайн сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход тус сав газрын захиргааны саналыг үндэслэнэ.” гэж заасны дагуу хуульд нийцүүлэн Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын 2.1 дэх заалтад, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл үйл ажиллагааг тасралтгүй, тогтмол явуулах үүднээс 2.4 дэх заалтад тус тус холбогдох өөрчлөлтийг оруулж байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ